

**ГХБХБГ-ЫН 04 ДҮГЭЭР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2019.04.04.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Онцгой байдлын газар болон иргэн Ерланы газрын маргаанд Шүүгч Мерамбектэй хамт газар дээр нь очиж хэмжилт хийж зураг гаргасан.</p> <p>“Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 10 иргэнд 13447 м2, Нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 20 иргэнд 13091 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тус тус өмчлүүлсэн болно.</p> <p>Эзэмшил газрын зориулалт өөрчлүүлэхийг хүссэн 2 иргэн, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хүссэн 1 ААНБ, Газар эзэмшигчийн оноосон нэр өөрчилж газар эзэмшихийг хүссэн 1 төрийн байгууллага, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлж зориулалт өөрчлүүлэхийг хүссэн 1 ААНБ, 2 иргэний хүсэлтийг тус тус холбогдох материалын хамт хүлээн авч аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан ЗДТГ-т хүргүүлэв. Мөн 1 төрийн байгууллага, 1 ААНБ, 3 иргэнд тус тус аймгийн Засаг даргын шийдвэрийн дагуу гэрээ байгуулж газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож Улсын бүртгэлд оруулав.</p> <p>“Өлгийланд”, “Эл эм ланд” ХХК-ын хийсэн 28 газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

<p>авч кадастрын мэдээллийн санд оруулсан болно.</p> <p>Мөн сумдын даамлуудын үйлдэж өгсөн 6 газрын кадастрыг хянаж бүртгэлд оруулав.</p> <p>Алтанцөгц сум: Сумын нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна.</p> <p>1 иргэний нэгж талбарын хувийн хэргийг ЛМ2 програмын цахимд архивласан.</p> <p>Хилийн цэсийн шугамын гадна талд байгаа зөрчилтэй нэгж талбарын судалгааг гаргаж ГХБХБГ-ын газарт хүргүүлэв. Мөн шинээр газар эзэмшүүлэх 3 өргөдөл хүлээн авч бүртгэв.</p>		
---	--	--

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

